



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот

Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.11, 71.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 252 дугаар тогтоолоор батлагдсан “Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх журам”-ын 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” төрийн бус байгууллагыг үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагаар бүртгэсүгэй.

2. Үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэсэнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ТББ /Ц.Бүрэнжаргал/-д үүрэг болгосугай:

1/ Хуулийн этгээдийн бүртгэл болон бусад эрх бүхий этгээдийн бүртгэлд өөрчлөлт оруулах, шинэ бүтэц зохион байгуулалтын дагуу байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган явуулах;

2/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 74, 75 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 252 дугаар тогтоолоор батлагдсан “Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах.

3. Энэ тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Н.Батсэлэнгэ/-нд, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Т.Жамбаажамц/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000360